ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 20 өдөр Дугаар 155 Улаанбаатар хот

"Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-ийг батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор батлагдсан, Засгийн газрын 2020 оны 65 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-ийн 4.3.2 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г энэхүү тогтоолын Нэгдүгээр, "ХХЗХ-ны 2024 оны орлогын төлөвлөгөө"-г Хоёрдугаар, "ХХЗХ-ны 2024 оны зардлын төлөвлөгөө"-г Гуравдугаар, "ХХЗХ-ны 2024 оны хөрөнгө оруулалтын зардал"-ыг Дөрөвдүгээр, "ХХЗХ-ны 2024 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал"-ыг Тавдугаар, "ХХЗХ-ны 2024 оны үйл ажиллагааны зардал"-ыг Зургаадугаар, "ХХЗХ-ны 2025-2026 оны төсвийн төсөөлөл"-ийг Долоодугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, батлагдсан зардал, төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД Ч.ЗОЛБАЯР

Ө.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 155 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ДД	Зорилт	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
НЭГ. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ЗОРИЛТУУДЫГ ХАНГАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ							
1.1. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.							
1	Сүлжээний бүсчилсэн топологи, сүлжээний үйлчилгээний газарзүйн ялгаваргүй тарифын зохицуулалт хэрэгжүүлэх	1-1-1.1	Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээний үйлчлэх нутаг дэвсгэр, үйлчилгээний хүртээмж, зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрлөөр судалгаа хийж, сүлжээний бүсчилсэн топологи, газарзүйн ялгаваргүй тарифын талаар зохицуулалтын санал боловсруулах	ЗЗҮТЗГ	ЗБХГ	3-4-р улирал	Судалгааны үр дүнд үндэслэн зохицуулалтын саналын хувилбар боловсруулж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
2	Нээлттэй сүлжээний зарчим, дэд бүтэц хамтран ашиглах зохицуулалт хэрэгжүүлэх	1-1-2.1	Харилцаа холбооны шугам, сүлжээний мэдээллийн санг (Netmap) Монгол Улсын дэд бүтцийн орон зайн өгөгдлийн геопорталтай холбож, нэмэлт хөгжүүлэлт хийх	ЗБХГ		Жилдээ	Мэдээллийн санг (Netmap) дэд бүтцийн орон зайн өгөгдлийн мэдээллээр баяжуулсан байна.
3		1-1-2.2	Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтэц хамтран ашиглаж байгаа нөхцөл байдлыг тодорхойлох	ЗБХГ		2-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс сүлжээ, дэд бүтэц хамтран ашигласан талаарх судалгаа, мэдээллийг гаргаж танилцуулсан байна.
4		1-1-2.3	Харилцаа холбооны идэвхгүй шугам, сүлжээг хамтран ашиглах баримт бичгийн төслийг боловсруулж, үйлчилгээ эрхлэгчидтэй зөвлөлдөх арга хэмжээг авах	ЗБХГ		3-4-р улирал	Зөвлөлдөх баримт бичгийн (consultation paper) төсөлд үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчдээс санал авч тусгасан байна.
5	Шуудангийн харилцан холболтыг нэмэгдүүлэх, бүсчилсэн тогтолцоо нэвтрүүлэх	1-1-3.1	Шуудангийн харилцан холболтын орлого хуваах зарчмыг тодорхойлох	ЗЗҮТЗГ	ШЗГ	1-2-р улирал	Олон улсын туршлага, судалгаанд үндэслэж, шуудангийн харилцан холболтын орлого хуваах зарчмын саналыг боловсруулж, холбогдох газар, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

6		1-1-3.2	Цахим худалдаа эрхлэгч болон шуудангийн хүргэлтийн үйлчилгээ эрхлэгч хоорондын хамтын ажиллагааг дэмжих	ШЗГ	ЗБХГ	2-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгч, хүргэлтийн үйлчилгээ эрхлэгчид болон цахим худалдаа эрхлэгчдийг хамруулсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
1.2. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ӨРСӨЛДӨӨН, ИННОВАЦИЙГ ДЭМЖИН, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖИХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.							
7	Дараа үеийн холболт, харилцан холболтын зохицуулалт, нээлттэй сүлжээний зарчмыг нэвтрүүлэх	1-2-1.1	Дараа үеийн холболт, харилцан холболтын зарчим, эдийн засгийн үр өгөөж, зохицуулалтын чиг хандлагын талаар судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ЗБХГ	1-2-р улирал	Судалгааны үр дүнд үндэслэн харилцаа холбооны үйлчилгээний холболт, харилцан холболтын зохицуулалтын санал боловсруулж, холбогдох газруудыг мэдээллээр хангаж, танилцуулга хийсэн байна.
8		1-2-1.2	Мэдээллийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгчдийн холболт, харилцан холболтын орлого хуваарилах зарчим, төлбөрийн талаар судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ЗБХГ	Жилдээ	Олон улсын туршлага, судалгааны үр дүнд үндэслэн зохицуулалтын санал боловсруулж, холбогдох газруудыг мэдээллээр хангаж, танилцуулга хийсэн байна.
9		1-2-1.3	Мэдээллийн сүлжээний талаарх хууль эрх зүйн орчин, техник технологи, үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлох, зохицуулалтын санал боловсруулах	ЗБХГ		1-3-р улирал	Мэдээллийн сүлжээний зохицуулалтын талаарх судалгааны үр дүн, зохицуулалтын саналыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
10		1-2-1.4	APNIC-тай хамтран интернэтийн засаглал, дундын холболтын төв (Internet Governance, IPv6, IXP)-ийн талаар сургалт зохион байгуулах	ЗБХГ		1-р улирал	Үйлчилгээ эрхлэгчид болон төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан байна.
11		1-2-1.5	Олон суваг дамжуулах болон телевизийн үйлчилгээ эрхлэгч хоорондын орлого хуваах зарчим, гэрээний нөхцөлийн талаар олон улсын туршлага судлах, зохицуулалтын санал боловсруулах	ЗЗҮТЗГ	ӨНЗГ	Жилдээ	Судалгааны үр дүнд үндэслэж, зохицуулалтын санал боловсруулж, танилцуулсан байна.
12		1-2-2.1	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судалгаа хийх	ЗЗҮТЗГ	РДЗХГ	2-3-р улирал	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
13		1-2-2.2	"Утасгүй холбооны технологид ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, баримтлах зохицуулалт, техникийн нөхцөл шаардлага" (WLAN) баримт бичгийг холбогдох техник, технологийн судалгаанд үндэслэн өөрчлөлт оруулах	РДЗХГ	ЗЗҮТЗГ	2-3-р улирал	Баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтийг Хорооны хуралдаанаар батлуулж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

14	Хязгаарлагдмал нөөц (Радио давтамж, Дугаарлалт) -ийг үр ашигтай удирдаж, шинэ технологи, инновацийн хэрэгцээ, ил тод байдлыг хангах	1-2-2.3	Дугаарлалтын олголт, ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах боломжийг тодорхойлох	ЗЗҮТЗГ	ЗБХГ	Жилдээ	Судалгааны хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс санал авч, үр дүнг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
15		1-2-2.4	Радио давтамжийн 108 МГц - 1000 МГц-ийн зурвасын хэрэглээ, олон улсад нэвтэрсэн шинэ технологийн судалгаа хийх, санал боловсруулах	РДЗХГ		1-р улирал	Судалгааны үр дүнд үндэслэж Радио холбооны дүрэм, Үндэсний радио давтамжийн хуваарилалттай нийцсэн эсэхийг тодорхойлж, саналыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
16		1-2-2.5	Радио холбооны "Хөдөлгөөнт дэлхийн станц (ESIM Earthstation in motion)"-ын талаар судалгаа хийх, холбогдох санал боловсруулах	РДЗХГ		1-р улирал	Судалгааны үр дүнд үндэслэн зохицуулалтын санал боловсруулж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
17		1-2-2.6	Шинэ технологийн нэвтрэлт, олон улсын радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтыг судалж, "Телевизийн өргөн нэвтрүүлгийн станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн шаардлага, норматив"-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах	РДЗХГ	ӨНЗГ	1-2-р улирал	Баримт бичгийн саналыг боловсруулан, ЦХХХЯ-нд саналыг хүргүүлж, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
18		1-2-2.7	ОУЦХБ-ын Радио холбооны дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлж "Радио давтамж, давтамжийн зурвасын хуваарилалтын зохицуулалт"-ын баримт бичиг боловсруулах	РДЗХГ		Жилдээ	Зохицуулалтын баримт бичгийн төслийг боловсруулж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
19		1-2-2.8	Радио станцын Монгол Улсын мастер бүртгэлийн ОУЦХБ-ын систем дэх бүртгэл, мэдээллийг сайжруулах	РДЗХГ		4-р улирал	ОУЦХБ-ын "Дэлхийн радио холбооны семинар" мастер бүртгэлийн сургалтад хамрагдаж, өөрийн орны мастер бүртгэлийн өгөгдөл, бүртгэлийг сайжруулах саналыг танилцуулсан байна.
20		1-2-2.9	5G үйлчилгээний үед шинээр нэвтрүүлэх боломжит үйлчилгээнүүд, тэдгээрийг Монгол Улсад нэвтрүүлэхэд зохицуулалтын орчин болон олон улсын чиг хандлагыг судалж, санал дүгнэлт боловсруулах	ЗБХГ	РДЗХГ ЗЗҮТЗГ	Жилдээ	Судалгааны үр дүнд зохицуулалтын санал боловсруулж танилцуулсан байна.
21		1-2-2.10	Мэдээлэл харилцаа холбооны салбар болон бусад салбартай хамтарсан "Инновац-технологи"-ийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	ЗБХГ		2, 4-р улирал	Хэлэлцүүлгийг жилдээ 2 удаа зохион байгуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

22		1-2-2.11	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох	РДЗХГ	Ажлын хэсэг	Жилдээ	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг Хорооны хуралдаанд танилцуулсан байна.
23		1-2-2.12	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох	РДЗХГ	Ажлын хэсэг	Жилдээ	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг Хорооны хуралдаанд танилцуулсан байна.
24	Өргөн нэвтрүүлгийн хараат бус нээлттэй байдлыг хангах, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх зохицуулалт хэрэгжүүлэх	1-2-3.1	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх	ӨНЗГ		1-2-р улирал	Үнэлгээ, дүгнэлтийг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний 2023 оны жилийн эцсийн үндсэн үзүүлэлт, эзэмшлийн талаарх мэдээлэл зэрэгт үндэслэн хийж, тайлбар, мэдээлэл бэлтгэн, байгууллагын цахим хуудсанд байршуулсан, олон нийтэд мэдээлсэн байна.
25		1-2-3.2	Зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл байдлыг үнэлэх, нээлттэй байдлыг хангах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн өөрчлөлтийн мэдээллийг гаргаж, олон нийтэд мэдээлэх	ӨНЗГ		Улирал бүр	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлийн хөдөлгөөний тоон мэдээг улирал тутам гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.
26		1-2-3.3	2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, батлуулах	ӨНЗГ		2-р улирал	2024 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрөл, тоог аргачлалын дагуу тодорхойлж, Хорооны хуралдаанаар батлуулсан байна.
27		1-2-3.4	2024 онд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, холбогдох шийдвэрийн биелэлтийг хангах	ӨНЗГ		Жилдээ	Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байна.
28		1-2-3.5	Телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг ил тод байршуулах www.copyright.crc.gov.mn системийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангах	ӨНЗГ		Жилдээ	Телевиз, ОСДҮЭ-дэд зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг байршуулах талаар заавар, арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн, хэрэгжилтийн байдлын талаар тайлан, дүгнэлт гаргаж, олон нийтэд мэдээлсэн байна.
29		1-2-3.6	Олон суваг дамжуулах үйлчилгээгээр дамжуулж байгаа гадаад улсын телевизийн жагсаалт, гэрээний мэдээллийг ил тод байршуулах дундын нэгдсэн систем хөгжүүлэх	ӨНЗГ		Жилдээ	www.copyright.crc.gov.mn дундын систем дээр нэмэлт хөгжүүлэлт хийж, гадаад сувгийн жагсаалт, гэрээний мэдээллийг байршуулах боломжийг бүрдүүлсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

30	Шуудангийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх	1-2-4.1	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд цахим худалдааны чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх	ШЗГ		2-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд цахим худалдааны чиглэлээр сургалт зохион байгуулж, гарын авлага, зөвлөмжөөр хангасан байна.
31		1-2-4.2	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд шуудангийн тээврийн хэрэгсэл, хүргэлтийн технологи болон гамшгийн үеийн ажиллагааны талаар зөвлөмж өгөх	ШЗГ		4-р улирал	Шуудангийн стандартууд, технологи ажиллагааны талаарх зөвлөмж боловсруулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хүргүүлсэн байна.
32	Хэрэглэгчийн сүлжээ, төгсгөлийн төхөөрөмжийн нэгдсэн стандарт хэрэгжүүлэх замаар хэрэглэгчийн сонголтыг чөлөөтэй болгох	1-2-5.1	Олон суваг, интернет, үүрэн, суурин холбооны үйлчилгээний үнэ тариф, хэрэглээний талаар мэдээлэл цуглуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	ЗЗҮТЗГ		Жилдээ	Судалгааны мэдээллийг холбогдох газруудад танилцуулж, тарифын мэдээллийг нийтэд ил тод байршуулсан байна.
33		1-2-5.2	Байгууллагын (corporate) интернэт хэрэглэгчийн онцлог, хэрэгцээ шаардлагын талаар судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ЗБХГ	2-3-р улирал	Судалгааны үр дүнд үндэслэж зохицуулалтын санал боловсруулж танилцуулсан байна.
34		1-2-5.3	Хэрэглэгчийн сүлжээ, (үүрэн, интернэт, ОСДҮ) хэрэглэгчийн төгсгөлийн төхөөрөмжийн нэгдсэн стандарт хэрэгжүүлэхэд чиглэсэн техник, технологийн судалгаа хийж судалгааны хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн систем, төгсгөлийн төхөөрөмжүүдийн өнөөгийн нөхцөл байдал (үйлдвэрлэгч, марк, төрөл гм), нийцэл, олон улсын туршлага, нэгдсэн стандарт хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох	ЗБХГ	РДЗХГ	Жилдээ	Судалгааны үр дүнд нэгдсэн стандарт хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг тодорхойлж, зохицуулалтын санал боловсруулсан байна.
1.3. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. ХАРИЛЦАА ХОЛБОО, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.							
35		1-3-1.1	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний чанарын тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж үнэлгээ, дүгнэлт өгөх	ЗЗҮТЗГ	ЗБХГ	3-4-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ирүүлсэн үйлчилгээний чанарын тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, үнэлгээ дүгнэлт гаргаж танилцуулсан байна.
36		1-3-1.2	Интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний чанарт хяналт тавих	ЗБХГ		Жилдээ	Интернэтийн чанарын мониторингийн speedtest.mn системийг ашиглан хэмжилт хийж, тайланг танилцуулсан байна.
37		1-3-1.3	Интернэт сүлжээний ачааллын менежмэнтийн нэгдсэн систем байгуулах талаар судлах	ЗБХГ	ЗЗҮТЗГ	Жилдээ	Сүлжээний ачааллын менежмэнтийн системийн техникийн шийдэл, хөрөнгө оруулалт, төсвийн тооцоо судалгаа хийж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

38	Харилцаа холбооны үйлчилгээний чанарын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	1-3-1.4	Үүрэн холбооны сүлжээний чанар хяналтын "ХХЗХ хэрэглэгч" аппликейшны хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж, үүрэн холбооны сүлжээний чанарыг хэмжих ажлыг зохион байгуулах	РДЗХГ		Улирал бүр	Олон нийтэд "ХХЗХ хэрэглэгч" аппликэйшн ашиглах зааварчилгааг сурталчилж, чанарын хяналтын тайланг (улирал бүр) нэгтгэн нээлттэй мэдээлсэн байна.
39		1-3-1.5	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүрэн холбооны сүлжээний хамрах хүрээг тооцоолох, мэдээллийг ил тод байрлуулах	РДЗХГ		2, 4-р улирал	Үүрэн холбооны операторуудын 2G, 3G, 4G, 5G технологийн бааз станцуудын байршлын хагас жил, бүтэн жилийн тайлан мэдээнд үндэслэн coverage.crc.gov.mn сайтад хамрах хүрээний мэдээллийг байршуулж, олон нийтэд мэдээлсэн байна.
40		1-3-1.6	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний чанарыг хянах зорилгоор үйлчлүүлэгчдээс цахимаар (QR код ашиглан) судалгаа авах боломж бүрдүүлэх, судалгаа авах	ШЗГ		Жилдээ	Шуудангаар үйлчлүүлэгчдээс цахим системээр судалгаа авч, тайланг танилцуулсан байна.
41		1-3-1.7	Дууны чанга дуугаралтын түвшингийн талаарх норматив/зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	ӨНЗГ		Жилдээ	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд норматив/зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлсэн байна.
42	Үндэсний радио долгионы хяналтын үйл ажиллагааг сайжруулах, бүсчилсэн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх	1-3-2.1	Үндэсний радио долгионы хяналтын үйл ажиллагаанд "MNS ISO/IEC 17020:2013 – тохирлын үнэлгээ, хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага" стандартыг нэвтрүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах	РДЗХГ		1-2-р улирал	Хяналтын төвийн үйл ажиллагаа нь MNS ISO/IEC 17020:2013 стандартын шаардлагуудыг хангаж байгааг нотлуулж, Үндэсний итгэмжлэлийн төвөөс итгэмжлэлийн гэрчилгээний хугацааг сунгаж авсан байна.
43		1-3-2.2	Үндэсний радио долгионы удирдлага, хяналтын нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх	РДЗХГ		Жилдээ	Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, төлөвлөгөөний дагуу төслийн суурь судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгэсэн байна. Бүсийн төвүүд болох Ховд, Дорнод аймагт болон Дархан хотуудад суурин хяналтын станц байршуулах газар эзэмших асуудлыг шийдвэрлүүлсэн байна.
44		1-3-2.3	Үндэсний радио долгионы хяналтын үйл ажиллагааг сайжруулах	РДЗХГ		Жилдээ	Радио долгионы хяналтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд радио давтамжийн 9 кГц - 8 ГГц-ийн зурвасыг хэмжих хөдөлгөөнт хяналтын станцыг авсан байна.
45		1-3-3.1	Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын лабораторийн төсөл хэрэгжүүлэх	РДЗХГ	ЗУХАГ	Жилдээ	Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, төлөвлөгөөний дагуу төслийн суурь судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгэсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

46	Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын төгтолцоонд лабораторийн баталгаажуулалт нэвтрүүлэх	1-3-3.2	Олон Улсын баталгаажуулалтын лаборатор (EMC, RF, Safety)-тай хамтран ажиллах	РДЗХГ		Жилдээ	Олон Улсын баталгаажуулалтын лаборатортой хамтран ажиллаж, инженер техникийн ажилчдыг сургалтад хамруулсан байна.
47		1-3-3.3	Баталгаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах	РДЗХГ		2, 4-р улирал	Баталгаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулж ХХЗХ-ны даргын тушаалаар батлуулсан байна.
48	Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглээнд төлөвшүүлэх	1-3-4.1	Дэлхийн шуудангийн байгууллагын "Олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичих уралдаан"-ыг орон даяар зохион байгуулах	ШЗГ		1-2-р улирал	Захидлын уралдааны үндэсний ялагчийн захидлыг олон улсын захидлын уралдаанд илгээсэн байна.
49		1-3-4.2	Орон нутагт шуудангийн нэгдсэн кодын ач холбогдол, хэрэглээг сурталчлах	ШЗГ		2-р улирал	Баруун бүсийн аймгуудын сум, хорооны ЗДТГ-ын ажилтнуудад шуудангийн нэгдсэн кодын хэрэглээний талаар сургалт зохион байгуулсан байна.
50		1-3-4.3	Шуудангийн нэгдсэн кодын цахим номын мэдээллийг шинэчлэх	ШЗГ		3-р улирал	Шуудангийн нэгдсэн кодын мэдээллийг сүүлийн байдлаар шинэчилж, www.zipcode.mn-д оруулсан байна.
51		1-3-4.4	Шуудангийн нэгдсэн кодын www.zipcode.mn цахим хуудасны хэвийн ажиллагааг хангах, мэдээллийн санг шинэчлэх, хөгжүүлэлт хийх	ШЗГ		Жилдээ	www.zipcode.mn цахим хуудасд шуудангийн нэгдсэн кодын өөрчлөлт, мэдээллийг оруулж шинэчилсэн байна.
52	Өргөн нэвтрүүлгийн орчинд үндэсний дархлааг хамгаалах, олон нийтийн	1-3-5.1	Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр олон нийтийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх	ӨНЗГ		Жилдээ	Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах, гомдол хүлээн авах чиглэлээр мэдээлэл, ярилцлага, нийтлэл бэлтгэж, радио, телевиз, цахим орчноор түгээж, олон нийтэд таниулсан байна.
53		1-3-5.2	Өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих зорилгоор үндэсний бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	ӨНЗГ		Жилдээ	Радио, телевизээр нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн бүтээл үйлдвэрлэлд гарсан өөрчлөлтөд үнэлгээ дүгнэлт, тайлан мэдээ гаргасан байна. Үндэсний түүх, соёл уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлсэн, хүүхдийн хоол хүнсний зөв зохистой хэрэглээ болон хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар шилдэг бүтээл, нэвтрүүлэгтэй радио, телевизийг шалгаруулж, урамшуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

54	нийтлэг эрх ашиг, үзэгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах	1-3-5.3	Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй телевизүүдэд дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай телевизийн нэвтрүүлгийн хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, холбогдох арга хэмжээ авах	ӨНЗГ		Жилдээ	2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн байдлаарх төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг гаргаж, цахим хуудсаар мэдээлсэн, судалгааны хамт холбогдох төрийн байгууллагад хүргүүлсэн байна.
55		1-3-5.4	Телевизүүдийн нэвтрүүлж байгаа дохионы хэлний хэлмэрч, хадмал тайлбартай нэвтрүүлгийн хүртээмж, зохицуулалтын үр дүн болон мэдээлэл авах хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар холбогдох байгууллага, сонсголгүй иргэдийн холбооноос санал, мэдээлэл авах	ӨНЗГ		Жилдээ	Холбогдох байгууллага, сонсголгүй иргэдийн холбоодтой уулзалтууд зохион байгуулж, үр дүнг танилцуулан, цахим хуудсаар мэдээлсэн байна.
56		1-3-5.5	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр батлагдсан аргачлал, зөвлөмж ("IPTV системийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал")-ийг хэрэгжүүлэхэд телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зүгээс авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар судлах	ӨНЗГ		Жилдээ	Телевизийн хадмал тайлбар бэлтгэн нэвтрүүлэх олон улсын туршлага болон телевизүүдийн хадмал тайлбартай нэвтрүүлэг бэлтгэж байгаа техникийн нөхцөл байдал, боломжийг судлан санал, дүгнэлт гаргасан байна.
57	Цахим орчинд хүүхдийн эрх, олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах	1-3-6.1	Цахим орчинд хүүхэд хамгааллын хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах	ЗБХГ		1-2-р улирал	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах семинар, хэлэлцүүлгийг олон улсын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.
58		1-3-6.2	Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын судалгаа хийх	ЗБХГ		1-2-р улирал	Судалгааны үр дүнг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн байна.
59		1-3-6.3	Цахим орчны контенттэй холбоотойгоор холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шийдвэрийн дагуу хууль зөрчсөн вэб сайт, контентод технологийн арга хэмжээ авах	ЗБХГ		Жилдээ	Эрх бүхий байгууллагуудаас ирсэн санал, дүгнэлт, шийдвэрийн дагуу зөрчилтэй вэбсайтыг "black-list.mn" системд бүртгэх, "Ногоон суваг" буюу "Content Reporting System (CRS)"-р хууль бус контентийг устгуулах хүсэлтийг хүргүүлэх зэрэг технологийн арга хэмжээ авсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

60		1-3-6.4	Цахим орчны зохицуулалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, олон нийтийн цахим аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах	ЗБХГ		Жилдээ	Цахим орчны зохицуулалтын талаарх хууль тогтоомж, олон нийтийн цахим аюулгүй байдлын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, олон нийтэд зориулсан арга хэмжээ, сургалт зохион байгуулсан байна.
61		1-3-6.5	www.ekids.mn вэб сайтаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх	ЗБХГ		4-р улирал	www.ekids.mn вэб сайтад харааны бэрхшээлтэй хүнд зориулсан нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.
1.4. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД, ШУУРХАЙ, ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ							
62	Зохицуулалтын үр нөлөө, үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тайлагнах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	1-4-1.1	Харилцаа холбооны үйлчилгээ тус бүрээр зах зээлийн нөхцөл байдал, олон улсын туршлага зэргийг судлан харьцуулалт, анализ хийх	ЗЗҮТЗГ		2-3-р улирал	Харилцаа холбооны үйлчилгээ тус бүрээр судалгааны тайлан, дүгнэлтийг гаргасан, Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, нээлттэй мэдээлсэн байна.
63		1-4-1.2	Сүлжээ хооронд харилцан холболт хийх, гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журамд үнэлгээ хийх	ЗЗҮТЗГ	ЗБХГ ӨНЗГ	Жилдээ	"Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу үнэлгээ хийсэн байна.
64		1-4-1.3	Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журамд үнэлгээ хийх	ЗЗҮТЗГ		3-4-р улирал	"Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу үнэлгээ хийсэн байна.
65		1-4-1.4	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	ӨНЗГ		Жилдээ	Олон суваг дамжуулах үйлчилгээ, радио телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг аргачлалын дагуу хийж, дүгнэлт санал гаргаж танилцуулсан байна.
66		1-4-1.5	Шуудангийн харилцан холболтын журамд үнэлгээ хийх	ШЗГ	ЗЗҮТЗГ	1-р улирал	"Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу үнэлгээ хийсэн байна.
67		1-4-1.6	Утасгүй холбооны нэвтрүүлэх болон хүлээн авах антеныг бүртгэх үйл ажиллагааны үндэслэл, процессыг тодорхойлох	РДЗХГ		1-2-р улирал	Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журамд антен бүртгэх талаар нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.
68		1-4-1.7	Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журамд үнэлгээ хийх	ЗБХГ		1-2-р улирал	"Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу үнэлгээ хийсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

69	Зохицуулалтын хэрэгжилт хангуулах тогтолцооны нотолгоонд суурилсан ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх	1-4-2.1	Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем (customer.crc.gov.mn)- д нэмэлт хөгжүүлэлт хийх	ЗУХАГ		Жилдээ	Тусгай зөвшөөрлийн customer.crc.gov.mn нэгдсэн системийг төрийн мэдээллийн үндсэн болон дэмжих системүүдтэй холболт хийж, мэдээлэл нийлүүлэх нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна. Тусгай зөвшөөрлийн төлбөр тооцооны программтай интеграц хийж, ажилтнуудын нэвтрэлтийг нэг болгох (SSO), батлагдсан хүсэлтийг автоматаар үүсгэдэг болгох, хэрэглэгч хүсэлт гаргахаасаа өмнө зөвшөөрлийн төлбөрийн тооцооллыг өөрөө хийдэг болгох, цаасаар ирсэн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хэрэглэгчийн системд үүсгэх, хэрэглэгч явцыг хянадаг болгох нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.
70		1-4-2.2	Тусгай зөвшөөрлийн бүртгэл, төлбөр тооцооллын програм (billing.crc.gov.mn)-д нэмэлт хөгжүүлэлт хийх, ашиглалт үйлчилгээг хангах	ЗУХАГ		Жилдээ	Тусгай зөвшөөрлийн бүртгэл, төлбөр тооцооллын програм (billing.crc.gov.mn)-д нэмэлт хөгжүүлэлт хийж, модулиудыг бүрэн ашиглалтад оруулсан, ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангасан байна.
71		1-4-2.3	Төрийн мэдээллийн үндсэн болон дэмжих системд (opendata.gov.mn) байгууллагын мэдээллийн системүүдийг интеграци хийх	ЗУХАГ		Жилдээ	Байгууллагын мэдээллийн (statistic.crc.gov.mn, number.crc.gov.mn) системүүдийг opendata.gov.mn системд API холболт хийсэн байна.
72		1-4-2.4	Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, эрхийн бичгийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	2024 онд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан, тусгай зөвшөөрлийн сунгалтын хүсэлтийн 50-иас доошгүй хувийг цахим хэлбэрээр хүлээн авсан байна.
73		1-4-2.5	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс статистик мэдээ, тайлан авч, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэх	ЗЗҮТЗГ		1, 3-р улирал	Дотоод журмын дагуу статистик тайланг боловсруулж байгууллагын цахим хуудас, тогтмол гаргадаг тайлан товхимол, ном сэтгүүлд мэдээлсэн байна. **%, Тайланд хамрагдсан үйлчилгээ эрхлэгч - 90%/86%**
74		1-4-2.6	Статистик мэдээллийн эмхэтгэл боловсруулах, мэдээлэх	ЗЗҮТЗГ		2-р улирал	2023 оны статистикийн мэдээллийн эмхэтгэл боловсруулж, байгууллагын цахим хуудсаар мэдээлсэн байна.
75		1-4-2.7	Харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлтүүдийн мэдээллийг ОУЦХБ-д хүргүүлэх, статистик үзүүлэлт, зааврыг шинэчлэн сайжруулах	ЗЗҮТЗГ		жилдээ	Шаардлагатай мэдээллийг, заасан цаг хугацаанд багтааж ОУЦХБ-д хүргүүлсэн байна. Харилцаа холбооны үйлчилгээний статистик мэдээ, тайлангийн үзүүлэлт, зааврыг шинэчлэн батлуулсан байна. ОУЦХБ-ын 2020 Статистик мэдээлэл цуглуулах гарын авлагыг шинэчилж (update хийх), байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн байна.
76		1-4-3.1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өдөрлөг "Экспо-2024" арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	ЗУХАГ		Жилдээ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өдөрлөг "Экспо-2024" арга хэмжээ зохион байгуулахад байгууллагын оролцоог хангаж ажиллана.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

77	Оролцогч талууд (Үйлчилгээ эрхлэгч, олон нийт, бусад)-тай нээлттэй, давтамжтай, үр ашигтай харилцаа бий болгох хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх	1-4-3.2	Хөрш оронтой хил орчмын радио давтамжийн зохицуулалтын асуудлаар уулзалт, арга хэмжээ зохион байгуулах	РДЗХГ		1-2-р улирал	БНХАУ-ын төлөөлөгчдийг хүлээн авч, хил орчмын радио давтамжийн зохицуулалтын асуудлаар уулзалт арга хэмжээ зохион байгуулсан байна.
78		1-4-3.3	Uptime Institute-тай байгуулсан Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах	ЗБХГ		Жилдээ	Талуудын хооронд байгуулсан санамж бичгийн 1.6-д заасан Хамтын ажиллагааны талаар санал солилцож, шийдвэрлэсэн байна.
79		1-4-3.4	Стандартчилал, норм, нормативын standard.crc.gov.mn нэгдсэн системийн ашиглалтыг хангуулж ажиллах	ЗБХГ		Жилдээ	Системд нэмэлт хөгжүүлэлт хийж, стандарт боловсруулахад оролцогч талууд системээр дамжуулж стандартын төсөлд санал авч, хэлэлцсэн байна.
80		1-4-3.5	Судалгааны байгууллагуудтай байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх	ЗБХГ		Жилдээ	МУИС-ийн МТЭС, ШУТИС-ийн МХТС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтарсан арга хэмжээнүүд зохион байгуулсан байна.
81		1-4-3.6	Мэдээлэл харилцаа холбооны салбарын нэр томьёоны dictionary.crc.gov.mn мэдээллийн сангийн системийг сайжруулан хөгжүүлэх	ЗБХГ		2-3-р улирал	Системд нэмэлт хөгжүүлэлт хийж, оролцогч талууд мэдээлэл харилцаа холбооны салбарын нэр томьёоны мэдээллийн системд мэдээлэл оруулах, системээр дамжуулж хэлэлцүүлэг хийх, санал авах боломж бүрдүүлсэн байна.
82		1-4-3.7	Хувийн болон дотоод хэрэглээний харилцаанд зориулан радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахдаа зөвшөөрөл авч ашиглах тухай зөвлөмжийг олон нийтэд хүргэх, хууль бус хэрэглээг багасгах	РДЗХГ		1-2-р улирал	Геологи, уул уурхай, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдэд Радио долгионы тухай хуулийн талаар мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн байна.
83		1-4-3.8	Баталгаажуулалтын үйл ажиллагааг сурталчлан таниулах талаар Гаалийн ерөнхий газартай хамтын ажиллагааг хөгжүүлэх	РДЗХГ		Жилдээ	Хилээр нэвтэрч буй харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажсан эсэхэд хяналт тавихаар Гаалийн ерөнхий газартай хамтын ажиллагааг өргөжүүлж, гаалийн мэргэжлийн байцаагч нарт сургалт зохион байгуулсан байна.
84		1-4-3.9	Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах эрхийн бичгийн зөвшөөрөл авахад хэрхэн баримт бичиг бүрдүүлэх талаарх зөвлөгөөг олон нийтэд өгөх	РДЗХГ	ЗУХАГ	2-3-р улирал	Харилцааны радио станцын зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалыг хэрхэн бэлтгэх тухай видео шторк хийж, олон нийтэд түгээсэн байна.
85	Оролцогч талууд (Үйлчилгээ эрхлэгч, олон нийт, бусад)-	1-4-4.1	"Шуудангийн салбарын зохицуулалт - 2024" зөвлөгөөн зохион байгуулах	ШЗГ		4-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчид болон холбогдох төрийн байгууллагуудын оролцоог хангаж, зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.
86		1-4-4.2	"Харилцаа холбооны зохицуулалт - 2024" зөвлөгөөнийг зохион байгуулах	ЗБХГ		4-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 60-аас доошгүй төлөөллийг оролцуулсан нэг удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
87		1-4-4.3	"Харилцаа холбооны хөгжил - 2024" бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулах	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	Баруун бүсэд зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

88	тай нэлттэй, давтамжтай, үр ашигтай харилцаа бий болгох хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	1-4-4.4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд харилцаа холбооны салбарын статистик тайлан мэдээ гаргах аргазүйгээр хангах	ЗЗҮТЗГ		Жилдээ	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд чиглэл бүрээр статистик тайлан мэдээ гаргах сургалтууд зохион байгуулсан байна.
89		1-4-4.5	Статистик тайлангийн маягт, зааврын эмхэтгэл, гарын авлага боловсруулах	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	2-3-р улирал	Гарын авлагыг хэвлүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг мэдээллээр хангах
90		1-4-4.6	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд шуудангийн салбарын хууль эрх зүй, стандарт, технологи ажиллагаа, цаг үеийн мэдээллээр хангах	ШЗГ		Сар бүр	Шуудангийн салбарын хууль эрх зүй, цаг үеийн мэдээлэл бүхий цахим сонинг сар бүр гарган, улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн байна.
91		1-4-4.7		ШЗГ		Жилдээ	Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, технологи ажиллагааны мэдээлэл бүхий 10 цуврал видео хичээл гарган, улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хилийн чанад дахь хамтрагч байгууллагуудад хүргүүлсэн байна.
92		1-4-4.8	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшил олгох сургалтыг ХМТС-тай хамтран зохион байгуулах	ШЗГ		2-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшил олгох сургалтыг ХМТС-тай хамтран зохион байгуулсан байна.
93		1-4-4.9	Татварын ерөнхий газартай хамтарч шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх	ШЗГ		1, 3-р улирал	Татварын ерөнхий газартай хамтарч НӨАТ-ын баримтын талаар шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд сургалт зохион байгуулсан байна.
94		1-4-4.10	"Дэлхийн радиогийн өдөр"-ийн хүрээнд олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил хийх	ӨНЗГ		1-р улирал	Олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажил (постер, нийтлэл) хийсэн байна.
95		1-4-4.11	"Дэлхийн телевизийн өдөр"-ийн хүрээнд олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил хийх	ӨНЗГ		4-р улирал	Олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажил (постер, нийтлэл) хийсэн байна.
96		1-4-4.12	Цахилгаан соронзон орны талаарх зөвлөмж, мэдээллийг олон нийтэд хүргэх, таниулах арга хэмжээ авах	РДЗХГ		2-4-р улирал	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчидтэй хамтарч цахилгаан соронзон орны нөлөөллийн талаарх судалгааны үр дүн, зөвлөмж, мэдээллийг олон нийтэд хүргэж, таниулах ажлыг зохион байгуулсан, байгууллагын цахим хуудсан дахь мэдээллийг баяжуулж, шинэчилсэн байна.
97		1-4-5.1	Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчээс ирж буй түгээмэл санал гомдолд хариу өгөх загвар боловсруулах	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	1-2-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчээс ирж буй түгээмэл гомдлуудад хариу өгөх загвар боловсруулж, холбогдох ажилтныг мэдээллээр хангасан, байгууллагын цахим хуудсанд оруулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

98	Гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг хялбаршуулах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх	1-4-5.2	Үүрэн холбооны дата үйлчилгээний үнэ тариф, хэрэглэгчээс ирүүлж буй гомдлын талаар судалгаа хийж, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх талаар арга хэмжээ зохион байгуулах	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	Жилдээ	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид, ШӨХТГ-тай хамтран үүрэн холбооны дата үйлчилгээний үнэ тариф, хэрэглээний талаар хэрэглэгчийг мэдээллээр хангасан байна.
99		1-4-5.3	Шуудангаар үйлчлүүлэгч ХХЗХ-той хэрхэн холбогдож, санал гомдлоо гаргах тухай мэдээллээр хангах	ШЗГ	ЗУХАГ	Жилдээ	Шуудангаар үйлчлүүлэгч гомдол гаргах үед ХХЗХ-той хэрхэн холбогдох мэдээлэл бүхий QR, sticker-ийг үйлчилгээний байранд байршуулсан байна.
100		1-4-5.4	"Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам"-ын процессыг боловсронгуй болгон шинэчлэх	ЗУХАГ		2-р улирал	"Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам"-ыг шинэчлэн батлуулсан байна.
1.5. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. САНХҮҮГИЙН ЗОХИСТ ХАРЬЦААГ ХАНГАХ, ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ							
101	Зохицуулалтын үйлчилгээний хөлс, хязгаарлагдмал нөөцийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг cost-cover зарчмаар шинэчлэн тогтоох	1-5-1.1	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох аргачлал боловсруулах	ЗЗҮТЗГ		жилдээ	Олон улсын байгууллага, гадаад улс орнуудын зөвлөх үйлчилгээнд тулгуурлан зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох дотоод аргачлалыг боловсруулж, танилцуулсан байна.
102		1-5-1.2	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох журмын хүрээнд холбогдох судалгаа хийж, хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	2-3-р улирал	ЦХХХЯ-наас баталсан Зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журмын хүрээнд зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн баталсан байна.
103	Авлага үүсэхээс сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх	1-5-2.1	Бодит бус авлага үүсэх эрсдлийг илрүүлж, арга хэмжээ авах	ЗУХАГ		жилдээ	Бодит бус авлага үүсэх эрсдлийг илрүүлж, арга хэмжээ авах зорилгоор зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх, олгох процесст үзлэг шинжилгээ хийж, санал дүгнэлтийг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
104	Зардал үр ашигтай зохицуулалтад чиглэсэн байдлыг хангах	1-5-3.1	2023 оны санхүүгийн тайланд зохистой харьцааны шинжилгээ хийх	ЗУХАГ		2-р улирал	Санхүүгийн зохист харьцааг 2023 оны санхүүгийн орлого, зардлын шинжилгээ болон олон улсад мөрдөгддөг нийтлэг стандартад нийцүүлэн тодорхойлж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
105		1-5-3.2	Байгууллагын санхүүгийн тайлангийн зардлын шинжилгээ хийх	ЗУХАГ		4-р улирал	Байгууллагын санхүүгийн зардлын зохистой харьцааны шинжилгээ хийж, дараа оны төсвийн төлөвлөгөөг боловсруулсан байна.
106		1-5-3.3	Байгууллагын орлогын бүтцийн зохистой харьцааг ханган, 2025 оны орлогын төсвийн төлөвлөгөө боловсруулах	ЗУХАГ	ЗЗҮТЗГ	4-р улирал	Байгууллагын 2025 оны орлогын төлөвлөгөөг боловсруулж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

107		1-5-3.4	Байгууллагын үйл ажиллагааны зардлын төлөвлөлтийг зах зээлийн бодит тооцоолол (ханш, хэрэглээний үнийн индекс, инфляцийн өсөлт зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүд) дээр үндэслэн гаргах	ЗУХАГ		4-р улирал	Байгууллагын дараа оны зардлын төлөвлөгөөг боловсруулсан байна.
1.6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. БАЙГУУЛЛАГА ҮНЭ ЦЭНЭТЭЙ КАПИТАЛАА НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ЧАДАМЖАА БАЙНГА ДЭЭШЛҮҮЛЖ, БҮТЭЭМЖ ДЭМЖСЭН СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ							
108	Байгууллагын хараат бус статусыг бэхжүүлэх, захиргаа удирдлагын тогтолцоог орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх	1-6-1.1	Харилцаа холбооны салбарын зохицуулалтын бодлого, чиглэлийг тодорхойлж, холбогдох баримт бичгээр баталгаажуулах	ЗЗҮТЗГ	Ажлын хэсэг	1-2-р улирал	Харилцаа холбооны салбарын зохицуулалтын бодлого, чиглэлийг тодорхойлж, холбогдох баримт бичгийн төслийг боловсруулж батлуулсан байна.
109		1-6-1.2	Байгууллагын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр Зохицуулах байгууллагын олон улсын мэргэжлийн холбоодтой бодлогын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, зөвлөгөө авах	ЗУХАГ		Жилдээ	Зохицуулах байгууллагын хуулийн этгээдийн статусыг тодорхойлох талаар ОУЦХБ (ITU), Дэлхийн худалдааны байгууллага (WTO) зэрэг олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох, бодлогын зөвлөлдөх албан уулзалтыг зохион байгуулсан байна.
110		1-6-2.1	Мэдээлэл харилцаа холбооны технологи, инновaци, эдийн засгийн чиглэлээр зохицуулалтын судалгаа хийхэд шаардлагатай олон улсын дата мэдээлэл цуглуулах, эх сурвалжийг бүрдүүлэх	ЗБХГ	Бүх газар	Жилдээ	Олон улсын судалгааны (Cullen) байгууллагаас судалгааны дата мэдээлэл авч, судалгааны сан үүсгэж, холбогдох зохицуулалтын судалгаа, шийдвэрт ашигласан, сургалт зохион байгуулсан байна. Судалгааны тайлан, нийтлэл гаргасан байна. **#, Ашигласан тайлангийн тоо**
111		1-6-2.2	Азийн өргөн нэвтрүүлэг, контентын салбарын судалгаа шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлж, судалгаа мэдээлэл авах	ӨНЗГ		Жилдээ	Азийн өргөн нэвтрүүлэг, контентын салбарын судалгаа шинжилгээний нийгэмлэг (Asian Video Industry Association)-тэй уулзалт, хэлэлцээ хийсэн байх, Азийн улс орнуудын өргөн нэвтрүүлэг, контентын зах зээлийн судалгааны тайлан мэдээлэл авч судалсан байна.
112		1-6-2.3	Дэлхийн радио холбооны их хурлаас гарсан шийдвэрийн дагуу үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг шинэчлэн батлуулах	РДЗХГ		Жилдээ	Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг ЦХХХЯ-аар батлуулж, зураглалыг (chart) шинэчлэн хэвлүүлсэн байна. Дэлхийн радио холбооны шинэчилсэн дүрмийг худалдан авсан байна.
113		1-6-2.4	Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн олон улсын нөхцөл байдал, зохицуулалтын чиг хандлагыг судлах	ӨНЗГ		Жилдээ	Олон улсын байгууллагуудаас гаргасан судалгаа, тайлан мэдээллийн хүрээнд туршлага судалж, мэдээлэл бэлтгэн, байгууллагын цахим хуудсанд байршуулж, ХХЗХ-ны сэтгүүлд хэвлүүлсэн байна.

114	Зохицуулалтын шийдвэрт ашиглах судалгаа, өгөгдлийн чадавхийг сайжруулах, өгөгдөл/мэдээлэл тандан судалгааны тогтолцоо бүрдүүлэх	1-6-2.5	Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн талаар бодлого, зохицуулалтын чиглэлийг тодорхойлоход шаардлагатай олон улсын туршлага, чиг хандлагыг судлах	ЗБХГ		Жилдээ	Олон улсын туршлага, чиг хандлагыг судалж, дараах баримт бичгүүдийг орчуулж, танилцуулсан байна. Үүнд: - Сингапурын Хувийн Мэдээлэл Хамгаалах Хороо (PDPC) - ноос 2020 онд хэвлэгдэн гарсан "Model AI Governance Framework" (Second Edition) - Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-аас 2021 онд хэвлэгдсэн "Emerging Technology Trends: Artificial Intelligence and Big Data for Development 4.0 "
115		1-6-2.6	Дижитал зохицуулалтын олон улсын чиг хандлага болон бусад улс орнуудын зохицуулах байгууллагуудын Sandbox зохицуулалтын арга барил нэвтрүүлсэн талаар судалгаа хийж, харилцаа холбооны салбарт "Сэндбокс зохицуулалтын орчин" бий болгох талаар санал боловсруулах	ЗБХГ	ЗУХАГ	Жилдээ	Судалгааны үр дүн, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийн талаар зохицуулалтын саналыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
116		1-6-2.7	Монгол Улсад Дата төвийн тохирлын гэрчилгээ олгох тогтолцоог бий болгоход шаардлагатай олон улсад өргөн хэрэглэгддэг Дата төвийн техникийн стандартыг судлах	ЗБХГ		Жилдээ	Олон улсад өргөн хэрэглэгддэг Дата төвийн техникийн стандарт ANSI/TIA-942 Revision B, (July 12, 2017) хувилбарыг худалдан авч, судлан Монгол Улсын дата төвийн тохирлын тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулсан байна.
117		1-6-2.8	Шуудангийн хөгжлийн чиг хандлага, дүрэм, стратегийн шинэчлэлийн талаар судалж, шуудангийн зохицуулалтын чиг хандлагыг тодорхойлох	ШЗГ		Жилдээ	Дэлхийн Шуудан холбоо, Дэлхийн гаалийн байгууллагын хамтарсан их хурал, АНДО-ын шуудангийн холбооны хуралд оролцож, шуудангийн хөгжлийн чиг хандлага, дүрэм, стратегийн шинэчлэлийн талаар мэдээлэл авч, шуудангийн зохицуулалтын чиг хандлагыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
118		1-6-2.9	Шуудангийн салбарт шинээр нэвтэрч буй техник технологи болон шинэ үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулах, судалгаа хийх	ШЗГ		Жилдээ	АНДО-ын шуудангийн байгууллагын үзэсгэлэн яармагт оролцож, танилцуулга бэлтгэн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийг мэдээллээр хангасан байна.
119		1-6-2.10	Өрхийн болон хувь хүний харилцаа холбооны хэрэглээ, үйлчилгээний хүртээмж, хэрэглэгчийн боловсрол, эрэлт хэрэгцээг тодорхойлох	ЗЗҮТЗГ		Жилдээ	Зөвлөх үйлчилгээний хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран судалгааны ажлыг зохион байгуулж, судалгааны үр дүнг Даргын зөвлөлийн хурал болон олон нийтэд мэдээлсэн байна.
120		1-6-3.1	Нэн шаардлагатай зохицуулалтын ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах	ЗУХАГ		Жилдээ	Ажилтнуудад сүүлийн үеийн зохицуулалтын арга, зарчмын талаар болон зохицуулагчийн ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтууд зохион байгуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

121	Байгууллагын соёл, ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд хүний нөөцийн удирдлагыг чиглүүлж, хараат бус өндөр бүтээмжтэй Зохицуулагч бий болгох тогтолцоо бүрдүүлэх	1-6-3.2	ISO9001 Чанарын менежментийн тогтолцоо, ISO30400 Хүний нөөцийн менежментийн тогтолцооны багц стандарт, байгууллагын хүний нөөцийн бодлого, 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд шинжилгээ хийх, тайлагнах	ЗУХАГ		4-р улирал	Зөвлөх үйлчилгээний хүрээнд ISO9001, ISO30400 хүний нөөцийн менежментийн тогтолцооны багц стандарт, байгууллагын хүний нөөцийн бодлого, 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд зөрүүгийн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
122		1-6-3.3	Чадахуйн буюу мерит зарчмын тогтолцоог бүрдүүлэх	ЗУХАГ		Жилдээ	Мерит зарчмыг холбогдох баримт бичгүүдэд загварчлан тусгаж, чадахуйд суурилсан зарчмаар хүний нөөцийг бүрдүүлэх, албан хаагчийг дэвшүүлэх, хөгжүүлэх, шилжүүлэх талаар арга хэмжээ авч ажилласан байна.
123		1-6-3.4	Ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн ур чадвар болон хувь хүний түвшинд сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх	ЗУХАГ		1-2-р улирал	Менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнасан байна.
124		1-6-3.5	Ажилтны бүтээмжийг дээшлүүлэх, шинэ санал санаачлагыг дэмжих, үнэлэх, хэрэгжүүлэх системийг хэрэгжүүлэх	ЗУХАГ		Жилдээ	Кайзен санал, чанарын дугуйлан ажиллуулах журам боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
125		1-6-3.6	Байгууллагын соёл, ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх ажил зохион байгуулах	ЗУХАГ		Жилдээ	- Шинэ ажилтан, албан хаагчийг чиглүүлэх хөтөлбөрийг ХХЗХ-ны даргын тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. - Мэдээлэл солилцооны сувгуудыг хөгжүүлж эхэлсэн байна. (ДМС, хурал, мэйл, харилцаа гэх мэт) - Ажлын байран дээр дасгал хийх хөдөлгөөн өрнүүлэх, ногоон оффис бий болгох зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.
126		1-6-3.7	Байгууллагын соёлын судалгаа хийж, үр дүнг танилцуулах	ЗУХАГ		4-р улирал	Байгууллагын соёлын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, Даргын зөвлөлийн хуралд тайлагнасан байна.
127		1-6-3.8	Байгууллагын ажилтан, албан хаагчдын хариуцлага, сахилга бат, ёс зүйг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах	ЗУХАГ		жилдээ	Ёс зүйн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна.
128		1-6-3.9	Ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх	ЗУХАГ		1-2-р улирал	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт ажилтан, албан хаагчдын 95%-ийг хамруулсан, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг стандартын дагуу хүргэсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

129	Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо (Дотоод аудит, босоо хяналт, процессын хяналт)-ын үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх.	1-6-4.1	ХХЗХ-ны үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээ хийх, тайлан бэлтгэх	ДХАА	Ажлын хэсэг	3-4-р улирал	ХХЗХ-ны "Үйл ажиллагааны эрсдэл таних, үнэлэх, баримтжуулах аргачлал"-ын дагуу үнэлгээ хийж, тайланг танилцуулсан байна.
130		1-6-4.2	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах олон улсын ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	ЗУХАГ		Жилдээ	Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичиг боловсруулж батлуулсан, ISO/IEC 27001 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн байна.
131		1-6-4.3	Байгууллагын үндсэн, дэмжих, үнэлгээ мониторингийн тодорхойлогдсон процессыг зураглах, нэгтгэх, баримт бичгийг боловсруулан, батлуулах	Ажлын хэсэг		1-р улирал	Байгууллагын үндсэн, дэмжих процессыг зураглаж нэгтгэх ба "ХХЗХ-ны процессын баримтжуулалт" баримт бичгийг ХХЗХ-ны даргын тушаалаар батлуулна.
ХОЁР. НИЙТЛЭГ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ (Хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх)							
дд	**Зохицуулалтын эрх хэмжээ**	**Дугаар**	**Үйл ажиллагаа**	**Хариуцах нэгж**	**Хамтрах нэгж**	**Давтамж/ Хугацаа**	**Гарц**
2.1. Нийтлэг эрх хэмжээ							
132	9.1.1.харилцаа холбооны талаар төрөөс баримталж буй бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;	2-1-1.1	Төрөөс баримталж буй бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах	Бүх газар		Тухай бүр	Харилцаа холбооны чиглэлээр төрөөс баримталж буй бодлогын талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна. *- ШЗГ нь үнэ бүхий шуудангийн тэмдэгт маркыг хадгалах бодлогын саналыг ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна. /ШтХ-25.3/* *- РДЗХГ нь Дэлхийн радио холбооны 2027 оны конгрессд оруулах саналыг ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна.* *- РДЗХГ нь хөрш орнуудтай байгуулах хил орчмын радио давтамжийн зохицуулалтын гэрээний төслийн саналыг ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна.* *- ЗЗҮТЗГ нь өрсөлдөөн, үнэ тарифын бодлогын чиглэлийн саналыг ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна.* *- Бусад;*
133		2-1-1.2	Салбарын болон холбогдох хууль, тогтоомжийн төсөлд өгөх байгууллагын саналыг боловсруулж нэгтгэх, хэлэлцүүлж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх	Бүх газар		Тухай бүр	Хууль тогтоомжийн төсөлд өгөх байгууллагын саналыг нэгтгэн, хэлэлцүүлж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.
134		2-1-1.3	Төрийн холбогдох байгууллагуудтай чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах	Бүх газар		Тухай бүр	Төрийн холбогдох байгууллагуудтай чиг үүргийн хүрээнд хамтран ажилласан байна.

135		2-1-1.4	Харилцаа холбооны салбарт хэрэгжиж байгаа Үндэсний хөтөлбөрүүд, мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн стратеги, хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, тайлагнах	Бүх газар		Жилдээ	Холбогдох хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн байдлыг тухай бүр гаргаж, тайлагнасан байна. *- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна;* *- Монгол Улсын радио давтамжийн хуваарилалтын дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг радио давтамжийн тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг эзэмшигчдийн үйл ажиллагаанд үндэслэн үнэлж, тайланг ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна;* *- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна;* *- Бусад;*
136		2-1-2.1	Тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	Бүх газар ХХНБД		Тухай бүр	Ирүүлсэн хүсэлтийг чанарын шалгуур үзүүлэлтүүдийг бууруулахгүйгээр хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.
137		2-1-2.2	Эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ шинээр авах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	ЗУХАГ	ЗБХГ, РДЗХГ	Тухай бүр	Эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ шинээр авах хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.
138		2-1-2.3	Мэдээлэл харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмжийг баталгаажуулах тохирлын гэрчилгээ шинээр олгох үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	РДЗХГ	ЗУХАГ	Тухай бүр	Хүсэлтийн дагуу үнэлгээ хийж, хуулийн хугацаанд дүгнэлт гарган шийдвэрлэсэн байна.
139		2-1-2.4	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	Бүх газар ХХНБД		Тухай бүр	Ирүүлсэн хүсэлтийг чанарын шалгуур үзүүлэлтүүдийг бууруулахгүйгээр хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.
140		2-1-2.5	Эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	ЗУХАГ	ЗБХГ, РДЗХГ	Тухай бүр	Эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээ сунгуулах хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

141		2-1-2.6	Тохирлын гэрчилгээний хугацаа сунгах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	РДЗХГ		Тухай бүр	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр шийдвэрлэж, тайлагнасан байна.
142		2-1-2.7	Тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ байгуулах	Бүх газар ХХНБД		Тухай бүр	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт гаргаж, тухай бүр шийдвэрлэсэн байна. Зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан үндэслэлд дүгнэлт хийж, хагас жил тутам тайлагнасан байна.
143		2-1-2.8	Тохирлын гэрчилгээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтэд үнэлгээ хийх, үнэлгээг нэгтгэж дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, гэрээ шинэчлэн байгуулах	РДЗХГ		Тухай бүр	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр шийдвэрлэж, тайлагнасан байна.
144		2-1-2.9	Тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болгох дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх, тайлагнах	Бүх газар ХХНБД		Тухай бүр	Хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт гаргаж, тухай бүр шийдвэрлэсэн байна. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон үндэслэлд дүгнэлт хийж, хагас жил тутам тайлагнасан байна.
145	9.1.2.хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ	2-1-2.10	Тусгай зөвшөөрөл олгосноос хойш хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, үйл ажиллагаагаа зогсоосон үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг гаргаж, хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт гаргаж, шийдвэрлүүлэх, тайлагнах	ЗУХАГ	Бусад газрууд ХХНБ	Улирал бүр	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дүгнэлт гаргаж, тухай бүр шийдвэрлэсэн байна. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлээгүй үндэслэлд дүгнэлт хийж, хагас жил тутам тайлагнасан байна.
146		2-1-2.11	Зөвшөөрлийн үйлчилгээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах	Бүх газар		Тухай бүр	Иргэн, хуулийн этгээдэд зөвшөөрлийн үйлчилгээтэй холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч, анхны иж бүрдлээр шийдвэрлэсэн хүсэлтийн хувийг нэмэгдүүлж ажилласан байна.
147		2-1-2.12	Тусгай зөвшөөрлийн нэгдсэн системийн (customer.crc.gov.mn) хэвийн ажиллагааг хангах	ЗУХАГ		Тухай бүр	Гүйцэтгэгчтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулж, бэлэн байдлын үзүүлэлтүүдийг гэрээний дагуу хангуулж ажилласан байна. ***#, Системийн бэлэн байдлын индекс***

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

148	байгуулах, биелэлтэд хяналт тавих;	2-1-2.13	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн (суурин холбоо) тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавих	ЗБХГ	ЗЗҮТЗГ	2-р улирал	Хяналт, шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. Гэрээний үүргийн биелэлтийг тусгай зөвшөөрөл тус бүрээр дүгнэж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулан, байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн байна. ***%, Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгч - 100%*** ***%, Гэрээний хэрэгжилт***
149		2-1-2.14	Харилцаа холбооны сүлжээний дугаарын журмын хэрэгжилтэд хяналт тавих	ЗБХГ		Жилдээ	Журмын хэрэгжилтэд хяналт хийж, тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, мэдээлсэн байна.
150		2-1-2.15	"Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг батлуулах	ЗБХГ	ЗУХАГ	1-2-р улирал	"Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг ХХЗХ-ны хуралдаанаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.
151		2-1-2.16	"Зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэх үйл ажиллагааны дотоод журам"-ын 6.2-6.4-т заасны дагуу 2024 онд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн гэрээний хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авах	ЗБХГ		Жилдээ	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хяналт шалгалт хийж, үр дүнг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна. ***#, Хяналт шалгалт хийгдсэн Харилцаа холбооны дэд бүтэц, үгсралт суурилуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо*** ***#, Хяналт шалгалт хийгдсэн Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо*** ***#, Хяналт шалгалт хийгдсэн Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо***
152		2-1-2.17	"Харилцаа холбооны сүлжээний мэдээллийн сан"-д баяжуулалт хийх, шинээр байгуулсан сүлжээний мэдээллийг оруулах	ЗБХГ		Тухай бүр	Тусгай зөвшөөрлийн хүсэлтэд үнэлгээ хийх, гэрээний үүргийн биелэлтэд хяналт шалгалт хийгдэх үед мэдээллийн санд (Netmap) бүртгэх шаардлагатай өгөгдлийг тухай бүр нэмж оруулсан байна.
153		2-1-2.18	Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэх маягтыг холбогдох аргачлалын дагуу боловсруулж батлуулах	ЗБХГ ӨНЗГ ШЗГ РДЗХГ	ЗЗҮТЗГ ЗУХАГ	3-4-р улирал	"Тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт дүгнэх ерөнхий аргачлал"-д заасан үнэлгээний маягтуудыг боловсруулж, Хорооны даргын тушаалаар батлуулсан байна.
154		2-1-2.19	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн байдалд төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалт хийх, гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэх	ӨНЗГ		Тухай бүр	Хяналт, шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. ***%, Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгч - 100%*** ***%, Гэрээний хэрэгжилт***

155		2-1-2.20	Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас ирүүлсэн албан хүсэлт, гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх	ӨНЗГ		Тухай бүр	Хяналт, шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. ***%, Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгч - 100%*** ***%, Гэрээний хэрэгжилт***
156		2-1-2.21	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хууль, дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, үнэлэн, тайлагнах	ШЗГ		Жилдээ	Шуудангийн үйлчилгээ эхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна. Үүнд: - Шуудангийн сүлжээ, үндсэн үйлчилгээ, буухиа - Улс хоорондын шуудангийн нэмэлт үйлчилгээ - Дотоодын шуудангийн нэмэлт үйлчилгээ
157		2-1-2.22	Шуудангийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэх, тайлагнах	ШЗГ		2-3-р улирал	Гэрээний үүргийн биелэлтийг тусгай зөвшөөрөл тус бүрээр дүгнэж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн байна.
158	9.1.4.сүлжээ хооронд харилцан холболт хийх, сүлжээнд холбогдох гэрээний ерөнхий нөхцөл, орлого хуваарилах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	2-1-3.1	Цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээний нөхцлийг хянах, гэрээг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, гомдол маргаантай асуудлыг шийдвэрлэх	ЗЗҮТЗГ	ЗБХГ	Тухай бүр	Харилцан холболт, сүлжээнд холбогдох нөхцөлийг журмын дагуу хянаж, гэрээг бүртгэн, сан үүсгэсэн байна. Гомдол, маргаантай асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хяналтын хугацаанд шийдвэрлэсэн байна. ***#, Нийт бүртгэлтэй гэрээний тоо*** ***#, Шинээр бүртгэсэн гэрээний тоо*** ***#, Шийдвэрлэсэн гомдол, маргааны тоо***
159		2-1-3.2	Интернэтийн бөөний үйлчилгээний сүлжээнд холбогдох нөхцөлийг хянах, гэрээг бүртгэх, хэрэгжилтэд хянал тавих, гомдол маргаантай асуудлыг шийдвэрлэх	ЗЗҮТЗГ	ЗБХГ	Тухай бүр	Харилцан холболт, сүлжээнд холбогдох нөхцлийг журмын дагуу хянаж, гэрээг бүртгэн, сан үүсгэсэн байна. Гомдол, маргаантай асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хяналтын хугацаанд шийдвэрлэсэн байна. ***#, Нийт бүртгэлтэй гэрээний тоо*** ***#, Шинээр бүртгэсэн гэрээний тоо*** ***#, Шийдвэрлэсэн гомдол, маргааны тоо***
160		2-1-3.3	Олон суваг дамжуулах сүлжээ, Газрын сүлжээнд холбогдох нөхцөлийг хянах, гэрээг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, гомдол маргаантай асуудлыг шийдвэрлэх	ЗЗҮТЗГ	ӨНЗГ	Тухай бүр	Харилцан холболт, сүлжээнд холбогдох нөхцлийг журмын дагуу хянаж, гэрээг бүртгэн, сан үүсгэсэн байна. Гомдол, маргаантай асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хяналтын хугацаанд шийдвэрлэсэн байна. ***#, Нийт бүртгэлтэй гэрээний тоо*** ***#, Шинээр бүртгэсэн гэрээний тоо*** ***#, Шийдвэрлэсэн гомдол, маргааны тоо***

161		2-1-3.4	Шуудангийн харилцан холболтын гэрээний нөхцөлийг хянах, гэрээг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, гомдол маргаантай асуудлыг шийдвэрлэх	ЗЗҮТЗГ	ШЗГ	Тухай бүр	Харилцан холболт, сүлжээнд холбогдох нөхцлийг журмын дагуу хянаж, гэрээг бүртгэн, сан үүсгэсэн байна. Гомдол, маргаантай асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хяналтын хугацаанд шийдвэрлэсэн байна. ***#, Нийт бүртгэлтэй гэрээний тоо*** ***#, Шинээр бүртгэсэн гэрээний тоо*** ***#, Шийдвэрлэсэн гомдол, маргааны тоо***
2.2. Харилцаа холбооны тухай хууль							
162	9.1.3.харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулах, холбогдох техникийн нөхцөл, шаардлага, норматив баримт бичиг, журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	2-2-1.1	Баталгаажуулалтын үйл ажиллагаанд "MNS ISO 17065:2013 Тохирлын үнэлгээ - бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага" стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах	РДЗХГ		4-р улирал	Баталгаажуулалтын үйл ажиллагаанд тавигдах стандартын шаардлагыг хангаж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
163		2-2-1.2	Харилцаа холбооны салбарын норматив баримт бичгүүдийг боловсруулж, батлуулах	ЗБХГ		Жилдээ	Харилцаа холбооны инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг Хорооны дэргэд 1-р улиралд багтаан байгуулж, 2024-2025 онд боловсруулах норматив баримт бичгийн жагсаалтыг 2-р улиралд батлуулсан байна. 2024 онд төлөвлөгдсөн норматив баримт бичгийг боловсруулж, батлуулсан байна.
164	9.1.5.харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг батлах, зах зээлд зүй ёсны монополь болон давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах, батлах;	2-2-2.1	Харилцаа холбооны зах зээлд зүй ёсны монополь болон давамгайлж буй үйлчилгээний тарифыг хянах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих	ЗЗҮТЗГ		Тухай бүр	Зүй ёсны монополь болон давамгай байдалтай үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний үнэ тарифт байнгын хяналт хийж, шаардлагатай тохиолдолд Хорооны хуралдаанд танилцуулж, тогтоол шийдвэр гаргуулсан байна.
165	9.1.6.харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	2-2-3.1	Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журмын хэрэгжилтийг хангах	ЗЗҮТЗГ		Жилдээ	Харилцаа холбооны зах зээлийн төлөв байдал, зохицуулалтын үйл ажиллагаанд шударга өрсөлдөх нөхцөл хангагдаж байгаа эсэх талаар үнэлгээ дүгнэлт хийж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

166	9.1.8.харилцаа холбооны стандарт боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	2-2-4.1	Харилцаа холбооны стандарт боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах	ЗБХГ		Жилдээ	2024-2025 онд боловсруулах Харилцаа холбооны стандарт, норматив баримт бичгүүдийн саналыг нэгтгэж, 1-р улиралд багтаан хөтөлбөр батлуулсан байна. Даргын тушаалаар баталсан хөтөлбөрт тусгагдсан стандартуудыг холбогдох хууль, тогтоомж, стандартад нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулсан байна. ***% Гэрээ байгуулсан стандартын тоо*** ***% Гэрээний хэрэгжилт***
167		2-2-4.2	Харилцаа холбооны салбарын стандартуудад үзлэг хийх	ЗБХГ		3-4-р улирал	Шуудангийн салбарын стандартуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу үзлэг хийж, дүгнэлтийг танилцуулсан байна.
168		2-2-4.3	Салбарын нэр томъёоны стандартууд болон тэдгээрийн хэрэглээний байдалд үзлэг, судалгаа хийх	ЗБХГ		Жилдээ	Стандарт хэмжил зүйн газрын нэр томъёоны стандартын техникийн хороо, салбарын судлаач, мэргэжилтнүүдтэй хамтран салбарын нэр томьёоны стандартуудад үзлэг хийж, сайжруулах санал боловсруулж, танилцуулсан байна.
169	9.1.9.сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;	2-2-5.1	Суурин холбоо, үүрэн холбоо, интернет протоколд суурилсан сүлжээний дугаар хуваарилах, олгох	ЗБХГ		Тухай бүр	Суурин холбоо, үүрэн холбоо, интернет протоколд суурилсан сүлжээний дугаарын хуваарилалт, олгохтой холбоотой харилцааг журмын дагуу зохион байгуулж,олон нийтэд мэдээлсэн, ОУЦХБ-д хүргүүлсэн байна.
170		2-2-5.2	Телефон ярианд суурилсан мэдээлэл лавлах үйлчилгээний дугаарын хуваарилалт, олгох үйл ажиллагааг зохион байгуулах	ЗБХГ		Тухай бүр	Телефон ярианд суурилсан мэдээлэл лавлах үйлчилгээний дугаарын олголтыг журмын дагуу шийдвэрлэж, олгосон дугаарын жагсаалтыг олон нийтэд мэдээлсэн байна.
171		2-2-5.3	Мессэжэд суурилсан мэдээлэл лавлах үйлчилгээний дугаарын хуваарилалт, олгох үйл ажиллагааг зохион байгуулах, арга хэмжээг хэрэгжүүлэх	ЗБХГ		Тухай бүр	Мессэжэд суурилсан мэдээлэл лавлах үйлчилгээний дугаарын олголтыг журмын дагуу шийдвэрлэж, олгосон дугаарын жагсаалтыг олон нийтэд мэдээлсэн байна.
172		2-2-5.4	Дугаарлалтын нэгдсэн системийн мэдээллийн санг шинэчлэх, хяналт тавих	ЗБХГ		Тухай бүр	Нэгдсэн системд дугаарын ашиглалтын мэдээллийг үнэн зөв ирүүлж байгаад хяналт тавьж, мэдээ тайланг боловсруулж, танилцуулсан байна.
173		2-2-5.5	Тусгай дугаарын үйлчилгээний зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах	ЗБХГ		Тухай бүр	Тусгай дугаарын үйлчилгээ эрхлэгчдийн дугаарын журмын биелэлтэд сар бүр түүврийн аргаар хяналт хийж, тайланг танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

174	9.1.12.тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;	2-2-6.1	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд үүссэн маргааныг эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Зохицуулах хороонд холбогдох маргаанд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалж оролцох	ЗУХАГ	Бусад газрууд	Тухай бүр	Хорооны үйл ажиллагаатай холбоотой аливаа зөрчил, маргаантай асуудлаар Шүүх, арбитр, хууль сахиулах, хяналтын байгууллагад итгэмжлэлийн үндсэн дээр Хороог төлөөлөн оролцох, тайлбар гаргах, нотлох баримтыг бүрдүүлэх зэргээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна. ***#, Хууль зүйн туслалцаа авсан маргаан***
175		2-2-6.2	Харилцаа холбооны зохицуулах хороонд ирсэн зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх	ЗУХАГ		Тухай бүр	Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.
176		2-2-6.3	Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргааны нэгдсэн санд баяжуулалт хийх, тайлагнах	ЗУХАГ		Хагас жил тутам	Шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй маргааны нэгдсэн санд тухай бүр баяжуулалт хийж, хагас жил тутам тайлагнасан байна. ***#, Зохицуулах хорооны шийдвэрийн эсрэг шийдэгдсэн маргаан***
177		2-2-6.4	Харилцаа холбооны үйлчилгээний талаар ирүүлсэн гомдлыг хүлээж авах, шийдвэрлэх, хариу өгөх, холбогдох арга хэмжээ авах, тайлагнах	ЗУХАГ	Бусад газрууд	Тухай бүр	Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний талаар ирсэн гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэж, тайланг улирал бүр Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, олон нийтэд мэдээлсэн байна. **# Гомдол шийдвэрлэсэн хувь**
178		2-2-6.5	Зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтэд хариу өгөх, шийдвэрлэх, нэгтгэн дүгнэж, тайлагнах	ЗУХАГ	Бусад газрууд	Тухай бүр	Зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд шийдвэрлэж, тайланг улирал бүр Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, олон нийтэд мэдээлсэн байна. **# Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн хувь**
179		2-2-6.6	Санал, гомдлын шийдвэрлэлтийн бүртгэлийн санг бүрдүүлж, улирал бүр тайлагнах, цахим хуудсаар мэдээлэх	ЗУХАГ		Улирал бүр	Санал, гомдлын шийдвэрлэлтийн тайлангуудыг нэгдсэн санд төвлөрүүлж, улирал бүр тайлагнасан байна
180		2-2-7.1	Домэйн нэр бүртгэгч байгууллагуудыг бүртгэн, мэдээллийн сан үүсгэх	ЗБХГ		Тухай бүр	Домэйн нэр бүртгэгч байгууллагуудыг бүртгэлийн журмын дагуу бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна. ***# Бүртгэлд хамруулсан байгууллага 100%***
181		2-2-7.2	Эрх бүхий төрийн байгууллагуудаас ирсэн санал, хүсэлт, дүгнэлтийн дагуу домэйн нэр болон IP хаягийн сангаас холбогдох мэдээллийг гаргаж өгөх	ЗБХГ		Тухай бүр	ЦЕГ, ШӨХТГ, Шүүх, Прокурор, ОӨГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг гаргаж, хүргүүлсэн байна.

182	9.1.14.домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	2-2-7.3	Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журмын хэрэгжилтийг хангуулах, холбогдох арга хэмжээ авах	ЗБХГ		Тухай бүр	Оролцогч талуудын журмын хэрэгжилтийг хангаж буй байдалд хяналт тавьж, үнэлэн, шаардлагатай арга хэмжээг авч ажилласан, хэрэгжилтийн байдлыг тайлагнасан байна.
183		2-2-7.4	Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулах	ЗБХГ	ЗУХАГ	3-4-р улирал	Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хорооны хуралдаанаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.
184		2-2-7.5	Домэйн нэртэй холбоотой иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх	ЗБХГ		Тухай бүр	Домэйн нэртэй холбоотой иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг хүлээн авч журам болон Олон Улсын Домэйн Нэрийн Маргаан шийдвэрлэх бодлого (Uniform Domain Name Dispute Resolution Policy - UDRP)-ын хүрээнд шийдвэрлэсэн байна. ***%, Гомдол шийдвэрлэлт***
185	9.1.15.тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах;	2-2-8.1	Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмыг батлуулах	ЗБХГ	ЗУХАГ ЗЗҮТЗГ	3-4-р улирал	Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмыг Хорооны хуралдаанаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлсэн байна.
2.3. Радио долгионы тухай хууль							
186	5^1.1.3.улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх;	2-3-1.1	Радио спектрийн талаарх судалгааны олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл авах	РДЗХГ		1-р улирал	Радио спектрийн талаарх судалгааны цахим хуудас болох GSA байгууллагын судалгаатай танилцах 1 жилийн эрхийг авч, судалгааны материалуудтай танилцсан байна.
187	5^1.1.5.Монгол Улсад бүртгэлтэй радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх;	2-3-2.1	Сансрын холбооны газрын станц болон газрын холбооны радио станцуудыг хөрш орнуудад мэдээлж, бүртгүүлэх	РДЗХГ		Тухай бүр	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх сансрын холбооны газрын станц болон газрын холбооны радио станцууд, тэдгээрт ашиглагдаж буй радио давтамж, радио давтамжийн зурвасын мэдээллийг хөрш орнуудад мэдээлэхээр ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

188	5[1].1.6.тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалтыг тусгай хэрэглээний радио давтамж ашиглах эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах;	2-3-3.1	Тусгай хэрэглээний ангилалд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт ба зохицуулалтын баримт бичиг нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай судалгаа хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, хэлэлцүүлэг зохион байгуулах	РДЗХГ		Жилдээ	Тусгай хэрэглээний байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, "Тусгай хэрэглээний радио давтамжийн зурвасын хуваарилалт ба зохицуулалтын баримт бичиг"-т нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ЦХХХЯ-нд хүргүүлсэн байна.
189	5[1].1.7.цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	2-3-4.1	Иргэн, хуулийн этгээд болон радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу цахилгаан, соронзон оронгийн хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх, холбогдох арга хэмжээ авах	РДЗХГ		Тухай бүр	Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилтийн нэгдсэн дүгнэлтийг Даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулсан байна.
190	15.1.Нэгдсэн бүртгэлд радио давтамжийн ангилал, зориулалт, ашиглагчийн нэр, хаяг, ашиглахыг зөвшөөрсөн радио давтамжийн зурвас, түүний өргөн, үйлчлэх хүрээ, газар зүйн байршил, ажиллуулах хугацаа, хүчин чадал, төлбөр төлөлтийн байдал зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр тусгана. 15.2.Нэгдсэн бүртгэлийг Зохицуулах хороо хөтлөх бөгөөд түүнийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр танилцуулна.	2-3-5.1	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх утасгүй холбооны нэвтрүүлэх антены байгууламжийг бүртгэлжүүлэх, тайлагнах	РДЗХГ		Улирал бүр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүсэлтийн дагуу нэвтрүүлэх антеныг бүртгэж, хаягжуулан, жилийн тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
191		2-3-6.1	Улаанбаатар хотын баруун бүсийн нутаг дэвсгэр дэх хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд ашиглаж буй радио төхөөрөмжийн радио давтамж ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх, тайлагнах	РДЗХГ		2-р улирал	Улаанбаатар хотын баруун бүсийн нутаг дэвсгэрт дэх радио тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд хяналт, шалгалт хийж, үр дүнг танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

192	20.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионы тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Зохицуулах хороо болон харилцаа холбооны улсын байцаагч хэрэгжүүлнэ.	2-3-6.2	Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх радио давтамжийн 20 МГц - 6 ГГц-ийн зурвасын ашиглалтын байдалд хэмжилт хийх, тайлагнах	РДЗХГ		Улирал бүр	Суурин хяналтын станцаар Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх радио давтамжийн 20 МГц - 6 ГГц-ийн зурвасын ашиглалтын байдалд хэмжилт хийж, үр дүнг танилцуулж, холбогдох арга хэмжээг авсан байна.
193		2-3-6.3	Улаанбаатар хотын хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн давтамжийн зурвасын ашиглалтын байдалд хэмжилт хийх, MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох, үр дүнг олон нийтэд мэдээлэх	РДЗХГ		Улирал бүр	Улаанбаатар хотын хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурваст хэмжилт хийж, MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоон, үр дүнг танилцуулж, олон нийтэд сар бүр мэдээлсэн байна.
194		2-3-6.4	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээний чанар, хамрах хүрээний хэмжилтийг хийх	РДЗХГ		Улирал бүр	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээний чанар, хамрах хүрээний хэмжилтийг хийж, үр дүнг танилцуулж, холбогдох арга хэмжээг авсан байна.
195		2-3-6.5	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглаж буй радио релей, линкний станц болон антен фидерийн байгууламжид үзлэг хийх, хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах	РДЗХГ		Тухай бүр	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглаж буй радио релей, линкний станц болон антен фидерийн байгууламжид үзлэг хийн хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Үр дүнг Даргын зөвлөлийн хуралд хагас жил тутамд тайлагнасан байна.
196		2-3-6.6	Орон нутагт радио давтамжийн 20 МГц - 6 ГГц-ийн зурвасын ашиглалтын байдалд хэмжилт хийх	РДЗХГ		Тухай бүр	Орон нутагт томилолтоор ажиллахдаа радио давтамжийн 20 МГц - 6 ГГц-ийн зурвасын ашиглалтын байдалд хэмжилт хийж, үр дүнг танилцуулан, холбогдох арга хэмжээг авсан байна.
197		2-3-6.7	Уул уурхай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдүүдийн радио тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх	РДЗХГ		3-р улирал	Төв, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгуудад уул уурхай ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдүүдийн радио тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авч, тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
198		2-3-6.8	Дархан-Уул, Орхон, Булган аймгуудад зөөврийн хяналтын төхөөрөмж суурилуулан өргөн зурвасын хэмжилт хийх, радио давтамжийн ашиглалтын байдлыг тодорхойлох, холбогдох арга хэмжээг авах	РДЗХГ		2-р улирал	Дархан-Уул, Орхон, Булган аймгуудад радио давтамжийн ашиглалтын байдлыг тодорхойлж, хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч, үр дүнг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

199		2-3-6.9	Орон нутагт радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглаж буй радио релей, линкний станц болон антен фидерийн байгууламжид үзлэг хийх, хяналт тавих, холбогдох арга хэмжээг авах	РДЗХГ		Тухай бүр	Орон нутагт томилолтоор ажиллахдаа радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд ашиглаж буй радио релей, линкний станц болон антен фидерийн байгууламжид үзлэг хийн хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Үр дүнг Даргын зөвлөлийн хуралд хагас жил тутамд тайлагнасан байна.
200	20.5.Радио долгионы тухай хууль тогтоомжийг зөрчсөн дараахь тохиолдолд радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох эрхийг Зохицуулах хороо эдэлнэ:	2-3-7.1	Радио давтамжийн ашиглалтын байдалд суурин хяналт хийх, хууль бус хэрэглээг илрүүлэх, холбогдох арга хэмжээг авах	РДЗХГ		Улирал бүр	Суурин хяналтын станцаар радио давтамжийн ашиглалтын байдалд тогтмол хэмжилт хийж, хууль бус хэрэглээг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
201		2-3-7.2	Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болсон радио давтамжийг чөлөөлөх арга хэмжээ авах	РДЗХГ		Тухай бүр	Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болсон радио давтамжийн ашиглалтын байдалд хэмжилт хийж, чөлөөлөх арга хэмжээг авсан байна. Үр дүнг хагас жил тутамд Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.
202		2-3-7.3	Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болсон тохиолдолд радио станцын антеныг буулгах, хэрэгжилтийг хангуулах	РДЗХГ		Тухай бүр	Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчингүй болсон тохиолдолд радио станцын антеныг буулгасан эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулсан байна.
203	20.2.Зохицуулах хороо нь харилцан нөлөөллийг арилгах, хууль тогтоомж зөрчсөн этгээдийг хайх, илрүүлэх үйл ажиллагааг радио давтамж эзэмшигчийн үйл ажиллагаанд саад хохирол учруулахгүйгээр зохион байгуулна.	2-3-8.1	Иргэн, хуулийн этгээд болон радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хэмжилт хийх, харилцан нөлөөллийг илрүүлэх, арилгах, холбогдох арга хэмжээг авах	РДЗХГ		Тухай бүр	Харилцан нөлөөллийг хайх, илрүүлэх, арилгах арга хэмжээг авч, үр дүнг Даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулсан байна.
204		2-3-8.2	Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулагч станцад радио давтамж, радио давтамжийн зурвас олгосонтой холбоотой харилцан нөлөөлөл үүсэх эсэхийг тодорхойлох хяналтын хэмжилт хийх	РДЗХГ		1-2-р улирал	Хэмжилт, судалгааны үр дүнд үндэслэж, радиогийн нэвтрүүлэгчийг харилцан нөлөөллөөс сэргийлэх талаар зөвлөмж боловсруулж радиогийн үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн байна.
205		2-3-8.3	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглагдах радио давтамжийн зурвасуудад хэмжилт хийх, тайлагнах	РДЗХГ		1-р улирал	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглахаар төлөвлөсөн зурвасуудад хэмжилт хийж, тайланг гарган, Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА А.ЛУВСАН-ОЧИР

206		2-3-8.4	Олон улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн байгууллагуудтай харилцан нөлөөллийг шийдвэрлэх, зохицуулах асуудлаар хамтран ажиллах	РДЗХГ		Тухай бүр	Олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд харилцан нөлөөллийг шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.
2.4. Шуудангийн тухай хууль							
207	9.1.3.шуудангийн нэгдсэн кодыг боловсруулах;	2-4-1.1	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлт орсон аймаг, дүүрэг, сум, баг, хорооны мэдээлэлд үндэслэн шуудангийн нэгдсэн кодыг оноох	ШЗГ		1-р улирал	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлт орсон аймаг, дүүрэг, сум, баг, хорооны мэдээлэлд үндэслэн шуудангийн нэгдсэн кодыг оноож, батлуулахаар ЦХХХЯ-руу хүргүүлсэн байна.
208		2-4-1.2	Батлагдсан шуудангийн нэгдсэн кодыг мэдээллийн санд оруулж (зураг, байршил, код) олон нийтэд мэдээлэх	ШЗГ		Жилдээ	ЦХХХЯ-аас шинээр батлагдсан шуудангийн нэгдсэн кодын мэдээллийг www.zipcode.mn цахим хуудсанд оруулсан байна.
209	9.1.6.шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх;	2-4-2.1	Дотоодын шуудангийн илгээмж хүргэх хугацаанд хяналт хийх	ШЗГ		2-3-р улирал	Улаанбаатар хотын дотор шуудангийн илгээмжийн хяналтын хугацааг аргачлалын дагуу хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн тогтоох саналыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, үр дүнг нийтэд мэдээлсэн байна.
210		2-4-2.2	Улс хоорондын шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох, үйлчилгээний чанарын хяналт хийх	ШЗГ		2-3-р улирал	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн илгээмжийн бүртгэл хяналтын системийн мэдээлэлд үндэслэн шуудангийн илгээмжийн хяналтын хугацааг тогтоож, Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, үр дүнг нийтэд мэдээлсэн байна.
211		2-4-2.3	Шуудангийн илгээмж хүргэх хугацааг шинэчлэн тогтоож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэн нийтэд мэдээлэх	ШЗГ	ЗУХАГ	1-р улирал	"Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоох тухай" 2023 оны 57 дугаар тогтоолд өөрчлөлт оруулан захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэн, нийтэд мэдээлсэн байна.
212	18.1.Үйлчлэгч нь дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээний тарифын талаархи саналаа үндэслэл, тооцооны хамт Зохицуулах хороонд хүргэнэ. 18.2.Зохицуулах хороо үйлчилгээний тариф тогтоох саналыг хянан үзэж, холбогдох саналаа 14 хоногийн дотор тухайн үйлчлэгчид хүргүүлнэ.	2-4-3.1	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчийн үнэ тариф тогтоох үндэслэлийг хянах, холбогдох саналыг хуульд заасан хугацаанд үйлчлэгчид хүргүүлэх	ЗЗҮТЗГ	ШЗГ	Тухай бүр	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчийн үнэ тарифыг хуульд заасан хугацаанд хянаж, хариу өгсөн байна.

213	24.1.1.Галт зэвсгийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.6-д заасан галт зэвсэг, сум, байлдааны зориулалттай галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан химийн хорт болон аюултай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл; 24.1.3.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3.1.1, 3.1.4-т заасан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эд;	2-4-4.1	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Шуудангийн тухай хуулийн 24.1.1, 24.1.3-р заалтыг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах	ШЗГ		1, 3-р улирал	Гаалийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагчидтай хамтарч, галт зэвсэг, сум, байлдааны зориулттай галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлийг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын хяналтын улсын байцаагчидтай хамтарч биологийн идэвхт бүтээгдэхүүнийг шуудангийн илгээмжээр илгээгдэхээс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хамруулсан байна. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийж, урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.
214	10.4.Илгээмжийг хүлээн авах, цуглуулах, тээвэрлэх, хаягт эзэнд хүргэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.13, 9.15-д заасан тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэхийг хориглоно.	2-4-5.1	Шуудангийн үйл ажиллагааг хууль бусаар эрхэлж байгаа этгээдүүдийг илрүүлэх, гомдлын дагуу шалгах, холбогдох арга хэмжээг авах	ШЗГ		Жилдээ	Хууль бусаар үйлчилгээ эрхэлсэн этгээдэд хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авсан, дотоодын шуудангийн хүргэлтийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх хуулийн заалтын талаар сургалт зохион байгуулж, тусгай зөвшөөрөл авах шаардлага хүргүүлсэн байна.
2.5. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль							
215	30.1.2.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2-5-1.1	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд маягтын дагуу хүлээн авч, нэгтгэн шинэчилж, олон нийтэд мэдээлэх	ӨНЗГ		1-р улирал	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх шинэчилсэн мэдээллийг Хорооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байна.
